



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/146/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Сайншанд хот  
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: [enkhtsetseg.e@audit.gov.mn](mailto:enkhtsetseg.e@audit.gov.mn)

Аудитор: О.Нарангарав

Цахим хаяг: [Narangarav.o@audit.gov.mn](mailto:Narangarav.o@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал .....	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21

Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,

Утас: (705) 2-27-34

2020.02.14 № 1-6/72

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД  
СУМ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Д.ЗОРИГОО ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020017

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга Д.Зоригоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дугаар сарын 17-ноос 2020 оны 01 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд” оршино.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх
- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль бус барааны эргэлттэй тэмцэх чадавхийг дээшлүүлэх
- Тарифын зохистой бодлого хэрэгжүүлэх, улсын төсвийн орлогыг бүрэн дүүрэн бүрдүүлэх
- Гаалийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, мэргэшсэн, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангах, хүний нөөцийг чадавхийг хөгжүүлэх
- Гаалийн байгууллагад өөрчлөлтийн менежмент, сайн засаглалыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх
- Хилийн хяналтыг зохицуулах менежментийг хэрэгжүүлэх, бараа тээврийн хэрэгслийн урсгалыг саадгүй болгох
- Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, бизнесийн таатай орчныг бий болгох, худалдааг хөнгөвчлөх
- Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх
- Мэдээллийн технологийг хөгжүүлэх, цаасгүй бүрдүүлэлтэд шилжих боломжийг бүрдүүлэх

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Юникус” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 50,540,041.3 мянган төгрөгөөс тооцон 101,080.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17,454.6 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлыг 2019 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр тооцсон, мөн гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзэж нийт зардлыг сонгон авч түүний 0.2 хувиар тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,983,679.9 мянган төгрөгөөр буюу 45.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага 200.2 мянган төгрөгөөр өсөж, бараа материал 17,365.0 мянга, үндсэн хөрөнгө 23,967,703.6 мянга, өр төлбөр 983.7 мянга, цэвэр хөрөнгө өмчийн дүн 23,982,696.2 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
				Зөрүү	
				Дүн	Хувь
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>163,363.35</b>	<b>147,387.01</b>	<b>(15,976.33)</b>	<b>-9.78</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
33	АВЛАГА	868.07	2,256.71	1,388.64	159.97
34	УРЬДЧИЛГАА	-	-	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	162,495.27	145,130.30	(17,364.97)	-10.69
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,835,803.46</b>	<b>28,868,099.89</b>	<b>(23,967,703.57)</b>	<b>-45.36</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	52,835,803.46	28,868,099.89	(23,967,703.57)	-45.36
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,999,166.81</b>	<b>29,015,486.90</b>	<b>(23,983,679.90)</b>	<b>-45.25</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,019.71</b>	<b>36.00</b>	<b>(983.71)</b>	<b>-96.47</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,019.71	36.00	(983.71)	-96.47
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>52,998,147.10</b>	<b>29,015,450.90</b>	<b>(23,982,696.20)</b>	<b>-45.25</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>52,999,166.81</b>	<b>29,015,486.90</b>	<b>(23,983,679.90)</b>	<b>-45.25</b>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь өмнөх оны авлага бүрэн барагдсан, харин тайлант онд байгууллагаас авах авлага 1,058.7 мянга, мал дутагдлаас 1,198.0 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17,365.0 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал 2,769.8 мянга, бичиг хэрэг 10,144.0 мянга, аж ахуйн материал 8,287.5 мянга, сэлбэг хэрэгсэл 814.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бэлэн бүтээгдэхүүн 1,410.0 мянга, түлш шатах тослох материал 10,083.1 мянга, барилгын засварын материал 360.6 мянга, бусад хангамжийн материал 26,053.6 мянга, мал амьтанд 850.0 мянган буурсантай холбоотой байна.

Тайлант онд ГЕГ-аас 15,447.8 мянган төгрөгийн гаалийн зөвшөөрлийн тэмдэг, ломбо, мэдүүлэг зэргийн материалыг, гаалийн шинэ цогцолбор байгуулахтай холбоотойгоор хуучин байгууламжийг буулгасантай холбоотой дахин ашиглах боломжтой гэж үзсэн 700 ширхэг бетон хавтанг 35,000.0 мянган төгрөгөөр үнэлэн орлого авсан, мөн малын нас дэвшилт, шинэ төлийн орлого 3,210.0 мянган төгрөгөөр нийт 53,657.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр бүртгэн авсан байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны А/27, А/65 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй 26,711.0 мянган төгрөгийн материалыг актлан, 15,000.0 мянган төгрөгийн бетон хавтанг Замын-Үүд цагдаагийн хэлтэс, Хилийн 0108-р анги, Замын-Үүд Тагнуулын газар зэрэг байгууллагуудад балансаас балансад шилжүүлэн, 14,500.0 мянган төгрөгийн бетон хавтанг тохижилтод зарцуулсан байна. Мөн малын нас дэвшилттэй холбоотой 2,718.0 мянган төгрөгийг бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь машин тоног төхөөрөмж 29,506.5 мянга, тавилга эд хогшил 9,038.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, барилга байгууламж 34,489,332.5 мянга, авто тээврийн хэрэгсэл 5,700.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 21,395.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, салбарын хөрөнгө оруулалтаар 2,573,054.3 мянган төгрөгийн барилга, барилгын сайжруулалтыг, 321,589.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг нэмж бүртгэсэн байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/313 дугаар тушаалаар “Хилийн боомтын дэд бүтэц” төслийн хүрээнд байгууллагын дансанд бүртгэлтэй 12,596,269.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан, ТӨБЗГ-ын тогтоолоор Зам тээврийн яаманд 24,778,557.5 мянган төгрөгийн хатуу хучилттай авто замыг балансаас балансад шилжүүлэн данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгөнд 378.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж үлдэгдэл 378.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 4,701,098.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал, балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 22,403.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, актлагдсан, балансаас балансад шилжсэн хөрөнгийн 10,710.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 983.7 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний авлага бүрэн барагдаж, харин тайлант онд түрээсийн орлогоос 36.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлэлтийг өглөг үүсгэн бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 29,015,450.9 мянган төгрөг болж 23,982,696.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсан нь шалтгаалжээ. Энэ нь тайлант онд үндсэн хөрөнгө болон бараа материалыг актлан, балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газарт тайлант онд 58,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 27,492.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 47.4 хувиар дутуу биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Дансны код	Орлогын ангилал	Тайлант оны		Тайлант оны зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,944,631.50	3,944,631.50	-	100.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	58,000.00	27,492.00	30,508.00	47.40
	<b>Нийт дүн</b>	<b>4,002,631.50</b>	<b>3,972,123.50</b>	<b>30,508.00</b>	<b>99.24</b>

Туслах үйл ажиллагааны орлого 30,508 мянган төгрөгөөр тасарсан нь "Гаалийн шинэчлэл" төслийн хүрээнд хилийн боомтыг Замын-Үүд Эдийн засгийн чөлөөт бүсэд нүүлгэн шилжүүлж, харилцагч байгууллагын түрээсийн гэрээг 2019.08.31-ны өдрөөр таслан зогсоосонтой холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 4,002,631.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,002,631.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3,944,631.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 58,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 3,944,631.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны цэвэр орлого 27,492.0 мянган төгрөг нийт 3,972,123.5 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,972,082.7 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна. Үүний: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 3,347,880.0 мянган төгрөг нь нийт зардлын 84.3 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 623,202.8 мянган төгрөг нь нийт зардлын 15.7 хувь тус тус эзэлж байна.

Жилийн эцэст урсгал зардлын хэмнэлт 1,040.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Замын-Үүд сумын Соёмбо хотхоны 2 орон сууцыг 2019 оны 10 сараас халаалтаар хангаж халаалтын төлбөрийг үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дансанд бүртгэж, жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 50,494.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 45,021.5 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 22,632.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч 12,488.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал:

- 2019 онд нийт 10,419.0 мянган төгрөгийн өртөгтэй 216 ширхэг принтерийн хор худалдан авч, 75 ширхэг 3,231.0 мянган төгрөгийн принтерийн хорыг зарцуулсан

- 6,813.9 мянган төгрөгийн бичгийн цаас худалдан авч, 3,932.7 мянган төгрөгийн бичгийн цаасыг албан хэрэгцээнд зарцуулсан байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Орлогын данстай холбоотой

**1.1. Илрүүлэлт:** Байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй орон сууцанд амьдардаг албан хаагчдын цалингаас орон сууцны төлбөрийг суутган авдаг боловч байгууллагын санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлгүй, цалингийн санд үлдээн цалингийн бусад зардалд зарцуулсан байна.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус зөрчсөн байна.

**1.2 Эрсдэл:** Үр дүн болон Мөнгөн гүйлгээний тайлан буруу тайлагнагдах эрсдэлтэй.

**1.3 Өгсөн зөвлөмж:** Цалингаас суутган авсан орон сууцны төлбөрийг Үр дүн, Мөнгөн гүйлгээний тайланд орлогоор хүлээн зөвшөөрч, зохих журмын дагуу захиран зарцуулж байх.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

## **2. Балансын данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй малын ашиг шимийн тооцооллыг санхүүгийн тайланд тусгадаггүй.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

**2.2 Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу тайлагнагдах эрсдэлтэй.

**2.3 Өгсөн зөвлөмж:** Малын ашиг шимийн тооцооллыг цаг тухай бүрд санхүүгийн тайланд бүртгэн, зохих журмын дагуу захиран зарцуулж байх.

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

## **3 Балансын данстай холбоотой асуудал**

**3.1 Илрүүлэлт:** Бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлээс 10 нэр төрлийн хөрөнгийн үлдэгдлийг тоолж, тулган баталгаажуулахад тооллогоор 1 төрлийн 38 ширхэг 1,900.0 мянган төгрөгийн бетон хавтан бүртгэлээс илүү гарсан. Мөн Хилийн боомт болон өөр агуулахад байгаа гэх 5 нэр төрлийн 276 ширхэг 9,527.7 мянган төгрөгийн хөрөнгийг тоолж чадаагүй болно.

Энэ нь Оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 200 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 13, 14, 18 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**3.2 Эрсдэл:** Хөрөнгөнд тавих хяналт сулрах

**3.3 Өгсөн зөвлөмж:** Бараа материал, үнэ бүхий зүйлийг эд хариуцагчийн агуулахад байрлуулан, эд хөрөнгийн тооллого хийх нөхцөлийг бүрдүүлэн, тооллого хийгдэж байгаа зүйл нэг бүрийг биечлэн үзүүлэн тооцуулж байх, агуулахын бүртгэл хөтлөх

**3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>163,363,346.18</b>	<b>147,387,011.47</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	868,072.60	2,256,712.36
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	611,757.93	2,256,712.36
3351	Байгууллагаас авах авлага	608,528.65	1,058,712.36
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,229.28	1,198,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	162,495,273.58	145,130,299.11
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,043,009.00	6,812,849.60
35110	Тусгай зориулалттай материал	4,043,009.00	6,812,849.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,961,227.00	3,551,227.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	137,591,037.58	120,339,222.51
35410	Бичиг хэргийн материал	7,950,815.29	18,094,792.99
35420	Аж ахуйн материал	55,089,975.59	63,377,506.59
35430	Сэлбэг хэрэгсэл	477,702.00	1,291,702.00
35440	Түлш, шатах тослох материал	19,695,073.76	9,611,961.49
35450	Барилгын засварын материал	1,332,223.01	971,653.84
35470	Бусад хангамжийн материал	53,045,247.93	26,991,605.60
35600	Мал амьтад	15,900,000.00	14,427,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,835,803,461.42</b>	<b>28,868,099,892.34</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	52,835,803,461.42	28,868,099,892.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	52,680,085,128.09	28,712,759,892.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	47,535,977,901.49	13,046,645,362.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,189,505,106.06)	(1,208,692,671.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	508,855,460.00	503,155,460.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(386,554,568.47)	(431,237,901.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,022,550,086.64	28,052,056,609.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,934,448,750.43)	(11,355,636,624.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	397,400,546.30	406,439,131.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(280,097,041.38)	(305,876,073.31)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,906,600.00	5,906,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	155,718,333.33	155,340,000.00
39301	Програм хангамж	5,600,000.00	5,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,221,666.67)	(5,600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	155,340,000.00	155,340,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>52,999,166,807.60</b>	<b>29,015,486,903.81</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,019,708.02</b>	<b>36,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,019,708.02	36,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,019,708.02	36,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,019,708.02	36,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	741,758.02	36,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>52,998,147,099.58</b>	<b>29,015,450,903.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	52,998,147,099.58	29,015,450,903.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,677,926,754.55	12,677,926,754.55
51101	Өмч: - төрийн	12,677,926,754.55	12,677,926,754.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	39,557,046,519.23	15,574,350,323.46
51210	Өмнөх үеийн үр дүн	39,557,046,519.23	39,557,046,519.23
51220	Тайлант үеийн үр дүн	-	(23,982,696,195.77)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	763,173,825.80	763,173,825.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>52,999,166,807.60</b>	<b>29,015,486,903.81</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>38,783,982,552.87</b>	<b>6,908,143,546.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>35,436,990,852.87</b>	<b>2,959,656,546.48</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	35,436,990,852.87	2,959,656,546.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,381,625,995.21	2,926,048,107.68
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,381,625,995.21	2,926,048,107.68
120005	Түрээсийн орлого	46,026,000.00	27,516,000.00
120009	Бусад орлого	9,338,857.66	6,092,438.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,346,991,700.00</b>	<b>3,948,487,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,346,991,700.00	3,944,631,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,346,991,700.00	3,944,631,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	3,855,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,855,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,714,381,369.80</b>	<b>8,727,308,750.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,714,381,369.80</b>	<b>8,727,308,750.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	8,662,858,996.94	8,722,412,472.61
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,506,370,297.80	2,981,464,731.51
210101	Үндсэн цалин	2,208,852,696.80	2,646,244,204.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,523,000.00	72,818,500.00
210104	Урамшуулал	234,994,601.00	262,402,027.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	301,143,144.27	372,213,395.56
210201	Тэтгэврийн даатгал	200,930,567.41	238,851,265.53
210202	Тэтгэмжийн даатгал	25,115,907.92	45,197,173.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,511,583.73	23,798,886.53
210204	Ажилгүйдлийн даатгал	4,962,280.86	5,851,458.40
210205	Эрүүл мэндийн даатгал	49,622,804.35	58,514,611.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	401,673,412.31	429,213,692.97
210301	Гэрэл, цахилгаан	259,878,227.46	274,238,657.10
210302	Түлш, халаалт	116,801,184.85	113,090,012.27
210303	Цэвэр, бохир ус	24,994,000.00	41,885,023.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,747,183.46	59,201,262.73
210401	Бичиг хэрэг	7,824,061.00	14,915,318.30
210402	Тээвэр, шатахуун	5,809,800.00	9,125,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,391,349.80	2,223,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,417,529.16	1,420,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,304,443.50	4,805,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	26,711,014.43
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,036,385.00	95,641,324.57
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,519,005.00	18,786,034.90
210604	Урсгал засвар	21,517,380.00	76,855,289.67
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,238,800.00	1,291,610.00
210702	Дотоод албан томилолт	2,238,800.00	1,291,610.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	99,490,461.50	78,054,370.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,814,930.50	59,556,360.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,051,870.00	3,999,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	503,600.00	1,400,090.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00

Дорноговь аймгийн Замын Үүд сум дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,180.00	705,579.00
210807	Газрын төлбөр	244,000.00	245,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,662,881.00	11,960,581.16
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,304,159,312.60</b>	<b>4,705,332,085.11</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,020,000.00	3,983,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,350.00	250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,303,064,962.60	4,701,098,345.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,522,372.86</b>	<b>4,896,277.75</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,522,372.86</b>	<b>4,896,277.75</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,522,372.86	4,896,277.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>30,069,601,183.07</b>	<b>(1,819,165,203.88)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>862,159.51</b>	<b>22,163,530,991.89</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	862,159.51	22,162,541,321.65
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	989,670.24
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(862,159.51)</b>	<b>(22,163,530,991.89)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>30,068,739,023.56</b>	<b>(23,982,696,195.77)</b>

## 4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,429,130,700.00</b>	<b>3,981,937,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>58,139,000.00</b>	<b>33,450,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	58,139,000.00	33,450,000.00
120005	Түрээсийн орлого	58,119,000.00	33,450,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,370,991,700.00</b>	<b>3,948,487,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,346,991,700.00	3,944,631,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,346,991,700.00	3,944,631,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	24,000,000.00	3,855,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,855,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,429,130,700.00</b>	<b>3,981,937,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,429,130,700.00</b>	<b>3,981,937,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,377,608,327.14</b>	<b>3,971,082,722.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,500,298,286.18	2,973,691,856.05
210101	Үндсэн цалин	1,434,029,186.18	1,834,490,156.05
210102	Нэмэгдэл	738,602,200.00	790,402,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,388,500.00	83,099,500.00
210104	Урамшуулал	226,000,000.00	265,700,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	300,626,432.20	374,188,100.00
210201	Тэтгэврийн даатгал	213,081,632.20	279,494,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,886,200.00	22,673,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,509,000.00	18,138,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,377,200.00	8,534,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,772,400.00	45,346,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	390,956,927.46	422,801,660.70
210301	Гэрэл, цахилгаан	274,878,227.46	274,899,049.10
210302	Түлш, халаалт	91,084,700.00	106,017,588.00
210303	Цэвэр, бохир ус	24,994,000.00	41,885,023.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,804,370.80	20,483,900.00
210401	Бичиг хэрэг	5,199,421.00	8,799,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,366,000.00	6,866,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,515,249.80	2,094,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,700.00	1,555,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,168,000.00	1,168,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	56,722,300.00	91,055,463.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,950,000.00	33,798,682.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,800,000.00	5,400,000.00
210604	Урсгал засвар	43,972,300.00	51,856,781.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,238,800.00	1,291,610.00
210702	Дотоод албан томилолт	2,238,800.00	1,291,610.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	108,886,860.50	86,954,132.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,984,030.00	56,349,860.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,051,870.00	3,999,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	503,600.00	1,400,090.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,725,460.50	8,525,500.00
210807	Газрын төлбөр	244,000.00	245,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,	6,190,900.00	16,246,922.00

	бэлтгэх		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	74,350.00	616,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,350.00	616,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,522,372.86</b>	<b>10,854,277.75</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	51,522,372.86	3,855,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,522,372.86	3,855,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	5,958,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,958,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,040,777.75
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,040,777.75

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	12,522,586,754.55	1,156,509,435.00	18,712,493,401.69	<b>32,391,589,591.24</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	155,340,000.00	0.00	-9,248,019,246.74	<b>-9,092,679,246.74</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>12,677,926,754.55</b>	<b>1,156,509,435.00</b>	<b>9,464,474,154.95</b>	<b>23,298,910,344.50</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-393,335,609.20	0.00	<b>-393,335,609.20</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Тайлант үеийн үр дүн			30,092,572,364.28	<b>30,092,572,364.28</b>
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,677,926,754.55</b>	<b>763,173,825.80</b>	<b>39,557,046,519.23</b>	<b>52,998,147,099.58</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,677,926,754.55</b>	<b>763,173,825.80</b>	<b>39,557,046,519.23</b>	<b>52,998,147,099.58</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>12,677,926,754.55</b>	<b>763,173,825.80</b>	<b>39,557,046,519.23</b>	<b>52,998,147,099.58</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-23,982,696,195.77	<b>-23,982,696,195.77</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,677,926,754.55</b>	<b>763,173,825.80</b>	<b>15,574,350,323.46</b>	<b>29,015,450,903.81</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,002,631,500.00	3,971,082,722.25	31,548,777.75	99.21
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,002,631,500.00	3,971,082,722.25	31,548,777.75	99.21
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,002,631,500.00	3,971,082,722.25	31,548,777.75	99.21
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,973,951,400.00	2,973,691,856.05	259,543.95	99.99
Үндсэн цалин	1,834,749,700.00	1,834,490,156.05	259,543.95	99.99
Нэмэгдэл	790,402,200.00	790,402,200.00	-	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	83,099,500.00	83,099,500.00	-	100.00
Урамшуулал	265,700,000.00	265,700,000.00	-	100.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	374,188,100.00	374,188,100.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	279,494,500.00	279,494,500.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	22,673,400.00	22,673,400.00	-	100.00
ҮОМШӨ-ний даатгал	18,138,700.00	18,138,700.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	8,534,700.00	8,534,700.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	45,346,800.00	45,346,800.00	-	100.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	422,878,700.00	422,801,660.70	77,039.30	99.98
Гэрэл, цахилгаан	274,900,000.00	274,899,049.10	950.90	100.00
Түлш, халаалт	106,084,700.00	106,017,588.00	67,112.00	99.94
Цэвэр, бохир ус	41,894,000.00	41,885,023.60	8,976.40	99.98
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,483,900.00	20,483,900.00	-	100.00
Бичиг хэрэг	8,800,000.00	8,799,100.00	900.00	99.99
Тээвэр, шатахуун	6,866,000.00	6,866,000.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,094,200.00	2,094,200.00	-	100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,700.00	1,555,700.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,168,000.00	1,168,900.00	(900.00)	100.08
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	91,057,600.00	91,055,463.50	2,136.50	100.00
Багаж, техник, хэрэгсэл	33,800,000.00	33,798,682.00	1,318.00	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,400,000.00	5,400,000.00	-	100.00
Урсгал засвар	51,857,600.00	51,856,781.50	818.50	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>	1,308,000.00	1,291,610.00	16,390.00	98.75
Дотоод албан томилолт	1,308,000.00	1,291,610.00	16,390.00	98.75

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	87,025,200.00	86,954,132.00	71,068.00	99.92
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,350,000.00	56,349,860.00	140.00	100.00
Даатгалын үйлчилгээ	4,053,000.00	3,999,760.00	53,240.00	98.69
Тээврийн хэрэгслийн татвар	1,417,700.00	1,400,090.00	17,610.00	98.76
Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,525,500.00	8,525,500.00	-	100.00
Газрын төлбөр	245,000.00	245,000.00	-	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,247,000.00	16,246,922.00	78.00	100.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	31,738,600.00	616,000.00	31,122,600.00	1.94
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	738,600.00	616,000.00	122,600.00	83.40
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,002,631,500.00	3,972,123,500.00	30,508,000.00	99.24
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,944,631,500.00	3,944,631,500.00	-	100.00
Улсын төсвөөс санхүүжих	3,944,631,500.00	3,944,631,500.00	-	100.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	58,000,000.00	27,492,000.00	30,508,000.00	47.40
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,000,000.00	27,492,000.00	30,508,000.00	47.40

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>3,855,500.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,855,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,855,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,855,500.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,855,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>3,855,500.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,855,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,855,500.00